



**МОНГОЛБАНК**  
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

## **МӨНГӨ, САНХҮҮГИЙН СТАТИСТИК**

Танилцуулга  
2017 оны 12 дугаар сар

Улаанбаатар  
2018



## МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ


Нийт M2 мөнгөний нийлүүлэлтийн 54.4 хувийг төгрөгийн хадгаламж бүрдүүлж байгаа бол 16.0 хувийг валютын хадгаламж, 14.0 хувийг төгрөгийн харилцах, 11.9 хувийг валютын харилцах, үлдсэн хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө бүрдүүлж байна.

M2 мөнгөний жилийн өсөлтийн түвшин 26.4 хувьд хүрч өмнөх сарынхаас 1.4 нэгж хувиар өссөн байна. Жилийн өсөлтийн дийлэнх буюу 77 хувийг төгрөгийн хадгаламж бүрдүүлж өсөлтөнд эзлэх хувь нь өмнөх сарынхаас 3.6 нэгж хувиар өсчээ. Мөн төгрөгийн харилцах нийт өсөлтийн 17 хувь, валютын харилцах 12 хувь, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 1.3 хувийг бүрдүүлж байгаа бол валютын хадгаламжийнх -7.0 хувь байна. Ам.долларын эсрэг төгрөгийн ханшийн чангаралт 3 дахь сардаа дараалан үргэлжилж, мөн цаашид ч


чангарах хүлээлт бүрэлдэж байгаа нь валютын хадгаламжаас төгрөгийн хадгаламж руу шилжих шилжилтээр харагдаж байна.

Мөнгөний нийлүүлэлт өмнөх сараас 7.0 хувь (1039.4 тэрбум төгрөгөөр)-иар өсч 15.8 их наяд төгрөгт хүрсэн байна. Үүнээс M1 мөнгө 7.1 хувь (186.5 тэрбум)-иар, бусад хадгаламж 7.0 хувь (852.9 тэрбум)-иар тус тус өссөн байна. Бусад хадгаламжийн бүрэлдэхүүн хэсгүүдээс төгрөгийн хадгаламж 717.5 тэрбум төгрөгөөр, валютын хадгаламж 7.7 тэрбум төгрөгөөр, валютын харилцах 127.7 тэрбум төгрөгөөр тус тус өсчээ. M1 мөнгөний бүрэлдэхүүн хэсгээс төгрөгийн харилцах 133.7 тэрбум төгрөгөөр, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 52.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Зураг 1. M2 мөнгөний жилийн өсөлтийн бүтэц




Зураг 2. M2 Мөнгөний сарын өсөлтийн бүтэц



M2 мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын гадаад цэвэр актив өмнөх сараас 1213.0 тэрбум төгрөгөөр өсч, дотоод цэвэр актив 173.7 тэрбум төгрөгөөр буурсан байна. Гадаад цэвэр активын өөрчлөлтөөс Төв банкны гадаад цэвэр актив 1666.0 тэрбум төгрөгөөр өсч, хадгаламжийн байгууллагуудынх 261.2 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Харин дотоод цэвэр активын өөрчлөлтөд Төв банкны дотоод цэвэр актив 1081.7 тэрбум төгрөгөөр буурч, хадгаламжийн байгууллагуудынх 908.0 тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна. Нийт хадгаламжийн байгууллагуудын дотоод активаас Засгийн газраас авах цэвэр авлага 657.8 тэрбум төгрөгөөр буурч, иргэдээс авах авлага 54.0 тэрбум төгрөгөөр, хувийн байгууллагынх 40.5 тэрбум төгрөгөөр тус тус өсчээ.


Зураг 3. Төв банк, хадгаламжийн байгууллагуудын гадаад, дотоод актив



Тайлант сард нөөц мөнгө 3.9 их наяд төгрөг байгаа нь өмнөх сараас 584.2 тэрбум төгрөг буюу 17.4 хувиар өссөн байна.

Нөөц мөнгөний 77.1 хувийг банкуудын Төв банк дахь харилцах, 15.5 хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө, 7.4 хувийг банкуудын касс дахь мөнгө бүрдүүлж байна.

Зураг 4. Нөөц мөнгө




### ЗЭЭЛ

Хадгаламжийн байгууллагуудаас олгосон зээлийн үлдэгдэл өмнөх сараас 116.8 тэрбум төгрөгөөр өсч 13.6 их наяд төгрөгт хүрчээ. Нийт зээлийн үлдэгдэл жилийн 9.6 хувиар, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 18.1 хувиар, хувийн хэвшлийнх 2.5 хувиар өссөн байна.

Банкуудаас хувийн секторт олгосон зээл 2017 оны 2 дугаар хагас жилээс эхлэн өмнөх оны мөн үетэй харьцуулахад

сүүлийн 6 сарын турш бууралттай байсан бол оны эцэст өсч эхэллээ. Эндээс иргэдийн хэрэглээний зээлтэй харьцуулахад чанаргүй зээлийн хувь өндөртэй бизнесийн зориулалттай зээл олголт нэмэгдэж эдийн засгийн үйл ажиллагаа сэргэж байгааг харуулж байна. Нийт зээлийн үлдэгдлийн 50.0 хувийг хувийн хэвшилд, 49.3 хувийг иргэдэд, 0.7 хувийг бусад салбарт олгосон зээл бүрдүүлж байна.

Зураг 5. Хадгаламжийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл, жилийн өсөлт



Хадгаламжийн байгууллагуудын зээлийг МИК ОССК-д шилжүүлсэн ипотекийн зээлийн багцтай нэтгэвэл өмнөх жилээс 10.9 хувиар өсчээ. Уг жилийн өсөлтийн 17 хувийг уул уурхай олборлолт, 8 хувийг худалдааны салбар, 5 хувийг боловсруулах үйлдвэрлэл бүрдүүлсэн байна. Харин МИК ОССК-д шилжүүлсэн багц 25 хувийг бүрдүүлжээ.

Нийт зээлийн үлдэгдлийн 14.1 хувь нь үл хөдлөх хөрөнгийн<sup>1</sup>, 13.8 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний, 10.2 хувь нь боловсруулах үйлдвэрлэл, 9.3 хувь нь барилгын, 7.6 хувь нь уул уурхайн салбарт, 24.1 хувь нь бусад салбаруудад ногдож байна. Харин цалин, тэтгэврийн зээл нийт зээлийн 20.9 хувийг бүрдүүлж байна.

Зураг 6. Зээлийн жилийн өсөлтийн задаргаа /гол салбараар/



Тайланд сард шинээр 1648.3 тэрбум төгрөгийн зээл олгосны 1039.7 тэрбум төгрөгийг хувийн байгууллагад, 580.9 тэрбум төгрөгийг иргэдэд олгожээ.


Нийт 1507.4 тэрбум төгрөгийн зээл төлөгдсөний 962.9 тэрбум төгрөгийг хувийг байгууллагаас, 520.6 тэрбум төгрөгийг иргэдийн зээлийн төлөлт бүрдүүлсэн байна.

Зураг 7. Тайланд сард шинээр олгосон болон төлөгдсөн зээл



<sup>1</sup> МИК-д шилжүүлсэн орон сууцны ипотекийн зээлийг хассанаар

Зураг 8. Тайлант сард шинээр олгосон зээл (салбараар)




Тухайн сард олгосон зээлийн 25.5 хувь нь худалдааны салбарт олгосон зээл байгаа бол 14.4 хувь нь боловсруулах үйлдвэрлэл, 11.6 хувь нь цалин, тэтгэврийн зээл, 10.7 хувь нь барилга, 5.5 хувь нь уул уурхай, 4.7 хувь нь үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбарт тус тус олгожээ.

Хувийн хэвшлийн зээлийн үлдэгдлийн 21.9 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар


үйлчилгээний салбарт, 19.4 хувь нь боловсруулах үйлдвэрт, 17.7 хувь нь барилгын салбарт, 14.5 хувь нь уул уурхай, олборлолтын салбарт ногдож байна.

Иргэдийн зээлийн үлдэгдлийн 46.7 хувийг орон сууцны ипотекийн зээл /МИК-д шилжүүлсэн багцыг оруулснаар/ бүрдүүлж байна. Цалин, тэтгэврийн зээл 31.0 хувийг, хадгаламж барьцаалсан зээл 4.9 хувийг, автомашины зээл 1.9 хувийг тус тус эзэлжээ.

Зураг 9. Хувийн байгууллагын зээлийн үлдэгдлийн бүтэц (салбараар)




Зураг 10. Иргэдийн зээлийн үлдэгдлийн бүтэц (салбараар)



Хугацаа хэтэрсэн зээлийн нийт зээлд эзлэх хувь сүүлийн 6 сарын хугацаанд 6-7 хувийн орчимд хэлбэлзэж байгаа бөгөөд тайлант сард өмнөх сарынхаас 0.6 нэгж хувиар буурч 6.6 хувьд хүрсэн байна. Харин чанаргүй зээлийн эзлэх хувьд 8.5-8.8 хувь орчимд хэлбэлзэж тайлант сард 8.5 хувьд байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн 83.3 хувийг, харин чанаргүй зээлийн 79.8 хувийг хувийн хэвшилд олгосон зээл эзэлж байна. Ийнхүү хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь бага зэрэг буурч байгаа нь эдгээр зээл эргэн төлөгдсөнтэй холбоотой.



Чанаргүй зээлийг эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзвэл усан хангамж, уул уурхай, мэргэжлийн шинжлэх ухаан болон боловсруулах үйлдвэрлэлийн салбаруудынх хамгийн өндөр байна.

Харин нийт чанаргүй зээлд эзэлж буй хувийг харвал уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл болон худалдааны салбар нийлээд нийт чанаргүй зээлийн 56 хувийг бүрдүүлж байна.



Нийт зээлийн ихэнх хувийг эзэлж байгаа хувийн байгууллагын чанаргүй зээлийн хувь хэмжээ 14 хувь байгаа бол улсын байгууллагын хувьд 21 хувь байна.

Иргэдийн чанаргүй зээлийн хувь хэмжээ 3 хувь байгаа нь харьцангуй бага байна.


Зураг 13. Чанаргүй зээлийн хувь (сектороор)



ЖДҮ эрхлэх зориулалтаар аж ахуйн нэгж болон иргэдэд олгосон нийт зээлийн үлдэгдэл 2.5 их наяд төгрөгт хүрчээ. Үүнээс 27.2 хувь буюу 670.9 тэрбум төгрөгийг бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний, 22.4 хувь буюу 552.7 тэрбум төгрөгийг боловсруулах үйлдвэрлэлийн салбарт олгосон байна. ЖДҮ-ийн зориулалтаар олгосон нийт

зээлийн 13.9 хувь нь чанаргүй зээлд ангилагдсан байна. Салбараар нь авч үзвэл ЖДҮ-ийн зориулалтаар аж ахуйн нэгжид олгосон зээлийн хувьд үйлчилгээний салбарын чанаргүй зээл 27.4 хувь, барилгын салбарынх 23.8 хувь байна. Иргэдэд олгосон зээлийн үлдэгдлийн барилгын салбарын чанаргүй зээл 15.1 хувь, боловсруулах үйлдвэрлэлийн салбар 14.7 хувь, үйлчилгээний болон хөдөө аж ахуйн салбарууд 14.4 хувьтай байна.

Зураг 14. ЖДҮ эрхлэх зориулалтаар олгосон зээлийн үлдэгдэл






## ИПОТЕКИЙН ЗЭЭЛ

2017 оны 12 дугаар сарын байдлаар ипотекийн зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 5.6 хувиар өсч 4253.2 тэрбум төгрөг<sup>2</sup> хүрчээ. Үүнээс орон нутагт олгосон ипотекийн зээлийн үлдэгдэл 765.7 тэрбум төгрөг байгаа нь нийт ипотекийн зээлийн 18.0 хувийг бүрдүүлж байна.

Ипотекийн зээлийн үлдэгдлийн 77.4 хувь нь хөтөлбөрийн зээл (орон нутгийн зээлийн хувьд 79.0), 19.9 хувь нь банкуудын өөрийн эх үүсвэрээр (орон нутагт 20.0), 2.7 хувь нь бусад эх үүсвэрээр (орон нутагт 0.9) олгосон зээл байна.

Зураг 15. Ипотекийн зээлийн үлдэгдлийн сарын өсөлт (санхүүжилтийн эх үүсвэрээр)



Зээлдэгчдийн тоо 93.1 мянгад хүрсний 73.0 хувь нь Улаанбаатар хотод, 27.0 хувь нь орон нутагт ногдож байна. Эдгээрийн 68970 нь хөтөлбөрийн зээлд, 20454 нь банкуудын өөрийн эх үүсвэрийн зээлд, 3723 нь бусад эх үүсвэрийн зээлд хамрагдсан байна.

Тайлант сарын хувьд 816 зээлдэгч шинээр ипотекийн зээлд хамрагдсанаас хөтөлбөрийн зээлд 477 зээлдэгч, банкны өөрийн эх үүсвэрийн зээлд 339 зээлдэгч хамрагдсан байна.

<sup>2</sup> Үүнд хөтөлбөрийн хүрээнд МИК руу шилжүүлсэн зээлийг оруулж тооцсон болно.

Зураг 16. Ипотекийн зээлийн үлдэгдэл, аймгуудаар



Ипотекийн зээлийн үлдэгдэлд хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувь өмнөх сараас 0.3 нэгж хувиар буурсан байна. 2017 оны 12 дугаар сарын байдлаар

хугацаа хэтэрсэн ипотекийн зээлийн 58.2 хувийг хөтөлбөрийн зээл, 38.2 хувийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 3.6 хувийг бусад эх үүсвэрийн зээл эзэлж байна.

Зураг 17. Ипотекийн зээлийн хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн хувь



ОНБ-уудын нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн<sup>3</sup> 98.3 хувь нь хэвийн зээл, 0.7 хувь нь хугацаа хэтэрсэн зээл, 1.0 хувь нь чанаргүй зээл байна.

<sup>3</sup> Үүнд МИК-д шилжүүлсэн зээлийг оруулж тооцоогүй болно.

Зураг 18. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь, аймгуудаар



Тухайн сард банкууд 60.9 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгосноос, 58.4 нь хувь хөтөлбөрийн, 41.6 хувь нь банкуудын өөрийн эх үүсвэрийн зээл байв.

Хөтөлбөрийн хүрээнд нийт 35.6 тэрбум төгрөгийн зээл шинээр олгож, 2.9 тэрбум төгрөгийн зээлийг дахин санхүүжүүлэв.

Зураг 19. Тайлант сард шинээр олгосон зээл



Тухайн сард 39.3 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөж, төлөгдсөн зээлийн хэмжээ өмнөх сараас 3.4 хувиар өсчээ. Үүний 8.1 тэрбум төгрөг нь хугацаанаас өмнө төлөгдсөн байна.

Улаанбаатар хотод худалдан авсан орон сууцны 33.8 хувь нь Баянзүрх дүүрэг, 23.7 хувь нь Хан-уул дүүрэг, 22.8 хувь нь Баянгол дүүрэг, 8.5 хувь нь Сонгинохайрхан дүүрэг, 11.1 хувь нь бусад дүүргүүдэд байршилтай байна.

Ипотекийн зээлийн үлдэгдлийн 82.0 хувь буюу 3487.5 тэрбум төгрөгөөр Улаанбаатар хотод, 18.0 хувь буюу 765.7 тэрбум төгрөгөөр орон нутагт байршилтай орон сууц худалдан авчээ.

Орон нутагт худалдан авсан барьцаа хөрөнгийн 52.8 хувь нь хүн амын суурьшил харьцангуй их байдаг Орхон, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Ховд аймгуудад байршилтай байна.

Зураг 20. Орон сууцны байршил, Улаанбаатар хот




Зураг 21. Барьцаа хөрөнгийн байршил, орон нутаг



Ипотекийн зээлийн үлдэгдлийн 90.7 хувь буюу 3856.5 тэрбум төгрөг 80м<sup>2</sup> хүртэлх талбай бүхий орон сууц худалдан авахад зарцуулагджээ. Эдгээрээс 40-60м<sup>2</sup> талбай бүхий орон


сууцны зээл давамгайлж байна. 80 м<sup>2</sup> хүртэл талбайтай зээлийн 85.2 хувийг хөтөлбөрийн эх үүсвэрээр, 12.3 хувийг банкуудын өөрийн эх үүсвэрээр, 2.5 хувийг бусад эх үүсвэрээр санхүүжүүлсэн байна.

Зураг 22. Барьцаа хөрөнгийн ашиглалтанд орсон он



2017 оны 12 дугаар сарын байдлаар ипотекийн зээлтэй нийт зээлдэгчдийн тоо 93147 байгаагийн 64.5 хувь нь 2 сая хүртэлх төгрөгийн өрхийн орлоготой бөгөөд 73.0 хувь нь Улаанбаатар хотод байршилтай орон сууц худалдан авчээ.

Зураг 23. Барьцаа хөрөнгийн талбайн хэмжээ




Худалдан авсан орон сууцных нь төрлөөр ангилан харвал зээлдэгчдийн 92.6 хувь нь нийтийн зориулалттай орон сууц, 6.1 хувь нь хашаа байшин, 1.4 хувь нь амины орон сууцанд зориулан ипотекийн зээл авсан байна.

Улаанбаатар хотод орон сууц худалдан авсан иргэдийн 32.7 хувь нь Баянзүрх, 23.4 хувь нь Баянгол, 19.9 хувь нь Хан-


Уул, 12.0 хувь нь Сонгинохайрхан, 7.1 хувь нь Сүхбаатар, 2.7 хувь нь Чингэлтэй, 2.2 хувь нь алслагдсан дүүргүүдэд орон сууц авчээ.

Зураг 24. Зээлдэгчийн орлого




Улаанбаатар хотод байршилтай орон сууцны зээлийн үлдэгдлийг дүүргүүдээр, орон сууц худалдан авсан иргэдийнх нь сарын орлогын түвшингээр нь ялган харвал Баянзүрх, Хан-Уул, Баянгол дүүргүүдэд орон сууц худалдан авсан зээлийн нийт ипотекийн зээлийн үлдэгдэлд эзлэх хувь орлогын түвшин бүрт 76.5-аас дээш хувийг эзэлж байна.

Зураг 25. Зээлдэгчийн орлого, барьцаа хөрөнгийн байршлаар, Улаанбаатар хот



Ипотекийн зээлтэй 93147 иргэдийн 20382 нь бөөний болон жижиглэн худалдаа эрхэлж, 17964 иргэн төрийн удирдлага, батлан хамгаалах, 6262 иргэн санхүү даатгал, 5155 иргэн уул уурхай, 4080 иргэн боловсрол, 4074 иргэн тээвэр агуулахын салбарт хөдөлмөр эрхэлж байна.

Зураг 26. Зээлдэгчийн насны ангиллаарх зээлийн үлдэгдэл



Зураг 27. Зээлдэгчийн хөдөлмөр эрхэлж буй байгууллагын үйл ажиллагааны салбар



Нийт зээлдэгчдийн 75.9 хувь нь 25-45 насны иргэд байгаа бөгөөд эдгээр зээлдэгчид нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 79.7 хувийг эзэмшиж байна.

Бүх насны ангилал дахь иргэдийн 68.0-аас дээш хувь нь Улаанбаатар хотод орон сууц худалдан авчээ.

## ХАНШ


2017 оны 12 дугаар сарын байдлаар Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартай харьцах дундаж ханш өмнөх сарынхаас 0.6 хувиар чангарч 2433.5 төгрөг байв. Тухайн сарын хамгийн өндөр ханш 2443.7 төгрөг байсан бол хамгийн бага нь сарын эцэст 2425.8 төгрөг байв. Сарын эцсийн ханш өмнөх сарынхаас 0.7 хувиар чангарсан байна.

БНХАУ-ын юаньтай харьцах дундаж ханш өмнөх сарынхаас 0.2 хувиар чангарч 369.0 төгрөг байв. Тухайн сарын хамгийн өндөр ханш нь 371.6 төгрөг байсан бол хамгийн бага нь 366.8 төгрөг байв. Харин сарын эцсийн ханш 371.6 төгрөг буюу өмнөх сарынхаас 0.5 хувиар чангарсан байна.

Зураг 28. Төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн ханш



Зураг 29. Төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн ханш




## ХҮҮ

Сүүлийн 6 сарын турш төгрөгийн шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү алгуур буурч тайлант сард 18.8%-д байгаа нь өмнөх сараас 0.8 нэгж хувиар буурчээ. Харин зээлийн үлдэгдэлд жигнэсэн хүү тогтмол түвшинд буюу 18.1% байна. Шинээр олгож буй зээлийн хугацааны хувьд урт болон богино хугацаатай зээлийн хүү харьцангуй бага хүүтэй байгаа бол зээлийн үлдэгдлийн хувьд хугацаа уртсах тусам хүү багасч байна.

Сектороор ангилан харвал хувийн байгууллагад шинээр олгосон зээлийн хүү 17.7%, иргэдэд олгосон зээлийн хүү 20.1% байна.


Зураг 30. Зээлийн жигнэсэн дундаж хүү



Валютын зээлийн хувьд тухайн сард шинээр олгосон зээлийн хүү өмнөх сарынхаас бага зэрэг буурч 11.6%, харин зээлийн үлдэгдлээр жигнэсэн хүү өмнөх сарын түвшинд буюу 11.2% байна.

Төгрөгийн хадгаламжийн үлдэгдлээр жигнэсэн хүү тогтмол байгаа бөгөөд сүүлийн 12 сарын дундаж хүү 13.0 хувь байгаа бол тайлант сарынх 12.9 хувь байна. Хадгаламжийн үлдэгдлийн хувьд хугацаа уртсах тусам хүү өсч байгаа бол шинээр татсан хадгаламжийн хувьд хугацааны хувьл хамаарал ажиглагдахгүй байна. Тухайн сард шинээр татсан төгрөгийн хадгаламжийн хүү 11.7 хувьд байна.

Зураг 31. Хадгаламжийн жигнэсэн дундаж хүү



## ИНФЛЯЦИ

2017 оны 12 дугаар сард инфляци УБ хотын хэмжээнд өмнөх сараас 0.3 хувиар өссөн байна. Үүнээс хүнсний барааны үнэ 0.3 хувиар буурч, хүнснээс бусад барааны үнэ 0.5 хувиар өссөн байна. Тодруулбал, сарын өсөлтийн 0.4 нэгж хувийг хүнснээс бусад барааны үнэ, -0.1 нэгж хувийг хүнсний барааны үнэ бүрдүүлжээ. Хүнснээс бусад барааны өсөлтөд автомашин, мотоцикл болон нийтийн хоолны үнийн өсөлт гол нөлөө үзүүлсэн байна. Харин хүнсний бүлгийн үнэ буурахад хонь, ямаа болон үхрийн махны үнийн бууралт гол нөлөө үзүүлэв.

Жилийн инфляци УБ хотын хэмжээнд тайлант сард 7.2 хувь байгаагийн 5.2 нэгж хувийг хүнснээс бусад бараа, үйлчилгээ, 2.0 нэгж хувийг хүнсний бараа, бүтээгдэхүүний үнэ бүрдүүлсэн байна.

Хүнсний бүлгийн үнэ жилийн 7.9 хувийн өсөлттэй байгаагаас хүнсний ногооны үнэ 20.3 хувиар, сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ 13.4 хувиар, мах, махан бүтээгдэхүүний үнэ 3.2 хувиар өсчээ. Харин хүнснээс бусад бараа үйлчилгээний бүлгийн үнэ жилийн 7.0 хувийн өсөлттэй байгаагаас тээвэр 10.5 хувиар, орон сууц, ус, цахилгааны үнэ 10.2 хувиар, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний үнэ 10.7 хувиар өсчээ.

Зураг 32. Улаанбаатар хотын жилийн инфляци



Зураг 33. Улаанбаатар хотын сарын инфляци

